



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/152/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: byanulgii@audit.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382

Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710

Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Ахлах аудитор: Х.Еркебулан

Утас: 70423073

Цахим хаяг: akon_erka@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16

1 Аудитын гэрчилгээ



АЙМГИЙН ОНОНРТ-ИЙН ЗАХИРАЛ
Н.ОСПАН ТАНАА

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,

Утас/факс: 70422954, 70422930

2017.02.15

№ 19

БМН - 2017/02-ТМЗ

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ОНОНРТелевизийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу ҮАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ОНОНРТелевизийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

ОНОНРТелевизийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Орон нутгийн олон нийтийн радио телевизийн захирал Н.Оспан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 02-р сарын 13-наас 2017 оны 02-р сарын 16-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 02-р сарын 17-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн

удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Х.Еркебулан хариуцаж хэрэгжүүлэв.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 01-р сарын 17-ны өдөр төрийн аудитын байгууллагад 2017 оны 01-р сарын 17-ны өдрийн №06–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Орон нутгийн олон нийтийн радио, телевиз “Аймгийн нийгмийн эдийн засгийн болон зах зээлийн харилцаан дахь олон талт шинэ соргог мэдээ мэдээллүүдийг олон нийтэд шуурхай хүргэх, төрийн бодлогыг анхан шатны нэгжид цаг алдалгүй хүргэхэд ил тод тус дэмжлэг үзүүлэх ардчилалыг хөгжүүлэх, үндэсний оюуны үнэт зүйлсийг дэлгэрүүлэх, танин мэдэхүйн болон шинэ технологийн ололтуудыг судлан сурталчилахад” оршино. /Үндэсний хэмжээнд үндэстэний цөөнх болон олон нийтийн эрх ашигт нийцсэн нэвтрүүлэх цацдаг орон нутгийн олон нийтийн радио телевизийг төлөвшүүлэн хөгжүүлэх, төр болон иргэдийн хооронд гүүр болж, ил тод, иргэний ардчилсан нийгмийг цогцлон байгуулахад хувь нэмрээ оруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор Орон нутгийн олон нийтийн радио телевизийн удирдах зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Орон нутгийн олон нийтийн радио, телевиз дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Орон нутгийн олон нийтийн радио, телевиз “Олон нийтийн радио телевизийн жилийн болон сарын төлөвлөгөөний дагуу мэдээ нэвтрүүлэг бэлтгэж явуулах, улиралын чанартай асуудал хөндсөн нэвтрүүлэг, нийтлэл гаргах ажлыг зохион байгуулна” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Олон нийтийн радио телевизийн тухай хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дагуу байгууллага нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөн явуулна. Төлөвлөгөөнд байгууллагын эрхэм зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэхтэй холбогдсон үндсэн арга хэмжээндүүдийг тусгаж, нийт ажилтны саналыг авч редакцийн зөвлөлөөр хэлэлцүүлж ажиллана.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Олон нийтийн радио телевизийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа.

Олон нийтийн радио телевизийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Accolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 10 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 30 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 10 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосонтой холбоотой юм.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 200.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 4.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар сонгосон нь эрсдэлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 24 хувь буюу асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	0	0.0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар зөвлөмж болгох асуудал, бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хариуцлагаа тооцуулах санал байхгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөрчилтэй асуудал илэрээгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Орон нутгийн олон нийтийн радио, телевиз өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 174.4 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	177.3	176.2	99.3%	1,1
1.1	Урсгал зардал	177.3	176.2	99.3%	1,1
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	177.3	176.2	99.3%	1,1
2.1	Улсын төсвөөс санхүүжих	159,6	158,5	99.3%	1,1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	9.0	9.0	100.0%	

Төсөвт зардлын гүйцэтгэл 99.3 хувь байгаа нь хэтрэлт байхгүй холбоотой байна. Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 125.6 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлогоос 8,6 сая төгрөгийн орлого оруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016.12.22-ны өдрийн 163 дугаар тогтоолын дагуу урсгал зардалд зарцуулсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар санхүүжилт аваагүй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад эрсдэлтэй асуудал тогтоогдоогүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Орон нутгийн олон нийтийн радио, телевиз 2016.09.01-ны өдрийн №17 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1089515.00</u>	<u>1403105.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1089515.00	1403105.00
354	Хангамжийн материал	1089515.00	1403105.00
35410	Бичиг хэргийн материал	417900.00	451900.00
35420	Аж ахуйн материал	435100.00	435100.00
35470	Бусад хангамжийн материал	236515.00	516105.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60046115.01</u>	<u>50993221.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	60046115.01	50993221.85
392	Биет хөрөнгө	60046115.01	50993221.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	154480392.00	154480392.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-127987319.70	-130561992.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30105000.00	6105000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20905000.00	-6105000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	85962582.40	93692582.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70022431.69	-76817558.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15286889.00	17686889.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6873997.00	-7487089.78
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>61135630.01</u>	<u>52396326.85</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>61135630.01</u>	<u>52396326.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	61135630.01	52396326.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48928941.00	48928941.00
512	Хуримтлагдсан үр дүн	-59933281.99	-68672585.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-59933281.99	-59933281.99
51220	Тайлант үеийн үр дүн		-8739303.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72139971.00	72139971.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>61135630.01</u>	<u>52396326.85</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	205977878.38	192029305.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13424278.38	19996605.00
120	Нийтлэг татварын бус орлого	13424278.38	19996605.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13424278.38	19996605.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8606899.00	11307405.00
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4817379.38	8689200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192553600.00	172032700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10481100.00	5784400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1800000.00	
131106	Төсвийн урамшуулал	8681100.00	5784400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182072500.00	159648300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182072500.00	159648300.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	6600000.00
133003	Хөрөнгийн		6600000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	222654050.60	194368608.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222359550.60	194368608.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	208574253.60	190921563.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139723263.38	134595400.00
210101	Үндсэн цалин	139723263.38	134595400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15290076.00	14333800.00
210201	Тэтгэврийн даатгал	15290076.00	14333800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18514612.62	17202223.00
210301	Гэрэл, цахилгаан	1074199.00	1051973.00
210302	Түлш, халаалт	15542313.00	14250250.00
210303	Цэвэр, бохир ус	1898100.62	1900000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4695049.38	2417537.00
210401	Бичиг хэрэг	1372820.00	706600.00
210402	Тээвэр, шатахуун	1773850.00	855300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	855779.38	855637.00
210404	Ном, хэвлэл	692600.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7951600.00	741100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	439000.00	269600.00

210604	Урсгал засвар	7512600.00	471500.00
2107	Томилолт, зочны зардал	700000.00	674900.00
210702	Дотоод албан томилолт	700000.00	674900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2818800.00	2389310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2638800.00	2038800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	185510.00
210803	Даатгалын үйлчилгээ		55000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		110000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18880852.22	18567293.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1800000.00	5784400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17080852.22	12782893.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13785297.00	3447045.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6179300.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5879300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7605997.00	3447045.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7605997.00	3447045.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	294500.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	294500.00	0.00
223001	Бусад хөрөнгө	294500.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16676172.22	-2339303.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	6400000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		6400000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-6400000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16676172.22	-8739303.16

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>205977878.38</u>	<u>185429305.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13424278.38	19996605.00
120	Нийтлэг татварын бус орлого	13424278.38	19996605.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13424278.38	19996605.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8606899.00	11307405.00
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4817379.38	8689200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192553600.00	165432700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10481100.00	5784400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1800000.00	
131106	Төсвийн урамшуулал	8681100.00	5784400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182072500.00	159648300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182072500.00	159648300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>203237878.38</u>	<u>181899305.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203237878.38	181899305.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189452581.38	178452260.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139723263.38	134595400.00
210101	Үндсэн цалин	139723263.38	134595400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15290076.00	14333800.00
210201	Тэтгэврийн даатгал	15290076.00	14333800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18514612.62	17202223.00
210301	Гэрэл, цахилгаан	1074199.00	1051973.00
210302	Түлш, халаалт	15542313.00	14250250.00
210303	Цэвэр, бохир ус	1898100.62	1900000.00
210304	Байрны түрээс		
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	3586729.38	2417537.00
210401	Бичиг хэрэг	426500.00	706600.00
210402	Тээвэр, шатахуун	1773850.00	855300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	855779.38	855637.00
210404	Ном, хэвлэл	530600.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7019100.00	1005100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	550000.00	533600.00
210602	Тавилга		

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	6469100.00	471500.00
2107	Томилолт, зочны зардал	700000.00	674900.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	700000.00	674900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2818800.00	2438900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2638800.00	2038800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	235100.00
210803	Даатгалын үйлчилгээ		55000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		110000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1800000.00	5784400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1800000.00	5784400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13785297.00	3447045.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6179300.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5879300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7605997.00	3447045.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7605997.00	3447045.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2740000.00</u>	<u>3530000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>2740000.00</u>	<u>3530000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>2740000.00</u>	<u>3530000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>2740000.00</u>	<u>3530000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2740000.00	3530000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2740000.00</u>	<u>-3530000.00</u>

3.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,928,941.00	72,139,971.00	- 59,933,281.99	61,135,630.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,928,941.00	72,139,971.00	- 59,933,281.99	61,135,630.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-8,739,303.16	-8,739,303.16
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,928,941.00	72,139,971.00	- 68,672,585.15	52,396,326.85

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177337500.00	176197860.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177337500.00	176197860.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177337500.00	176197860.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134595400.00	134595400.00
210101	Үндсэн цалин	112384900.00	134595400.00
210102	Нэмэгдэл	22210500.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14333800.00	14333800.00
210201	Тэтгэврийн даатгал	14333800.00	14333800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18047100.00	17202223.00
210301	Гэрэл, цахилгаан	2258200.00	1051973.00
210302	Түлш, халаалт	13888900.00	14250250.00
210303	Цэвэр, бохир ус	1900000.00	1900000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3372000.00	3347537.00
210401	Бичиг хэрэг	651700.00	706600.00
210402	Тээвэр, шатахуун	855300.00	855300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	935000.00	855637.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	930000.00	930000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3605100.00	3605100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	733600.00	733600.00
210602	Тавилга	2400000.00	2400000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	471500.00	471500.00
2107	Томилолт, зочны зардал	748500.00	674900.00
210702	Дотоод албан томилолт	748500.00	674900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2635600.00	2438900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2168800.00	2038800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	235100.00
210803	Даатгалын үйлчилгээ	55000.00	55000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131800.00	110000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177337500.00	176197860.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	159648300.00	158508660.00
132001	Орон нутгийн төсвөөс	159648300.00	158508660.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17689200.00	17689200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90000000.00	90000000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8689200.00	8689200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.0	18.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	18.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН

Огноо: 2017.02.17